

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2010-09-15/**

Ажлын хэсгийн хуралдаан 2010 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн 10 цагт Уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Ажлын хэсгийн гишүүн Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга С.Мягмардаш, Уул уурхайн үндэсний ассоциацийн Гүйцэтгэх захирал Н.Алгаа, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, Ил тод сангийн тэргүүн Д.Цэрэнжав, Инфорум төвийн тэргүүн А.Батпүрэв, Петрочайнэ Дачин Тамсаг ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Дэлгэрбаяр, ажлын хэсгийн гишүүдийг төлөөлж Эрдэс баялаг, эрчим хүчний яамны мэргэжилтэн Д.Бүүвэйжаргал, Татварын ерөнхий газрын Тусгай хяналтын хэлтсийн дарга Я.Пүрвээ, Газрын тосны газрын тасгийн дарга Э.Оюун, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Э.Эрдэнэтунгалаг, Нүүрс ассоциацийн менежер Э.Сарангэрэл, Бороо гоулд компанийн татварын нягтлан бодогч Г.Лхагва-Очир нар оролцов. Мөн хуралдаанд ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын Бүс нутгийн захирал Сэм Бартлет, ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, санхүүгийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, орчуулагч Б.Ганхуяг нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 25 гишүүн оролцох ёстой байсан боловч 13 гишүүн оролцож ирц 52 хувьтай байв.

Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Долгор гадаад томилолттой учир ажлын хэсгийн хуралдааныг удирдах үүргийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяад хариуцуулсан байв.

Ажлын хэсгийн хуралдааныг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа нээж, Сайн байцгаана уу. ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооноос баталгаажуулалтын тайлантай холбогдуулан хэд хэдэн чиглэлээр даалгавар өгсөн бөгөөд түүний хэрэгжилтийн явцыг шалгах зорилгоор Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын Бүс нутгийн захирал ноён Сэм Бартлет манай улсад айлчилж хэд хэдэн уулзалтуудыг зохион байгууллаа. Үүнтэй холбогдуулан бид ажлын хэсгийн хуралдааныг зарласан боловч зарим гишүүд маань ажилтай, гадаадад томилолттой явсан зэрэг шалтгааны улмаас ирсэнгүй. Өнөөдрийн хурлаар бид 2 асуудал хэлэлцэнэ. Нэгдүгээрт, Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны нэгдсэн тайлан гаргах явц, ажлын хэсгийн өнгөрсөн хуралдаанаас хойш зохион байгуулсан талаар Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулна. Үүнтэй холбогдуулж та бүхэнд шинэчилсэн 7 маягт болон түүнийг гаргах зааврыг хүргүүлсэн бөгөөд өнөөдөр санал хэлэлцэхгүйгээр дараа нь ажил хэргийн шугамаар авна. Өмнө нь бид ажлын хэсгийн хурлаараа маягыг 3 удаа хэлэлцэж, Үндэсний зөвлөлд танилцуулан батлуулах зөвшөөрөл авсан. Гэхдээ Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын оронд өөр төрлийн татварыг санал болгох буюу оруулах талаар Улсын Их Хурал дээр яригдаж байгаа тул үүнийг бид хүлээгээд байна. Иймд бид нэг мөр энэ оны 12 дугаар сард багтаж

шинэчилсэн маягт болон зааврыг батлуулах төлөвлөгөөтэй байна. Иймд та бүхэн маягттай холбоотой эцсийн санал болон өөрчлөлтөө ажлын албанд хүргүүлэхийг хүсч байна. Хоёрдугаар хэлэлцэх асуудал бол ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны шийдвэрийн биелэлтийг шалгасан байдлын талаархи танилцуулгыг ноён Сэм Бартлет танилцуулна. Дараа нь дотоод журмын төслийг танилцуулж, гишүүдийн зөвшөөрлийг авав. За ингээд хурлаа эхлэе.

1.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны тайлан гаргах ажлын явц, ажлын хэсгийн хуралдаанаас хойш хийсэн ажлын тухай танилцуулга

Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2009 оны нэгдсэн тайлан гаргах явц, ажлын хэсгийн хуралдаанаас хойш хийсэн ажлын талаар танилцуулав. Танилцуулгын эхэнд Ш.Цолмон та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ажлынхаа дундуур цаг зав гаргаж ажлын хэсгийн хуралдаа ирсэн явдалд талархаж байна. Юуны өмнө та бүхэнд өнөөдрийн хуралд оролцож буй шинэ хүмүүсээ танилцуулах нь зүйтэй байх. Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Гүйцэтгэх захирал Дэлгэрбаяр, Бороо Гоулд ХХК-ийн Татварын нягтлан бодогч Лхагва-Очир мөн манай ажлын албанд шинээр орсон Санхүүгийн мэргэжилтэн Дэлгэрмаа нар юм. Бид сүүлийн үед нилээд ачаалалтай ажиллаж байна. ОУ-ын Удирдах хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд олон ажил хийсэн байгаа. Үүний биелэлт үр дүн ямархуу байгаа талаар ноён Сэм Бартлет өөрөө танилцуулах байх. Иймд миний хувьд давхардуулахгүйгээр гол нь цаашид юу хийгдэх талаар танилцуулья. /Танилцуулгыг хавсаргав/

Э.Сумъяа: За Цолмонгоос асуух асуулт байна уу?

Д.Бүүвэйжаргал: Цөмийн энергийн газар ямар байр суурьтай байгаа вэ?

Ш.Цолмон: Цөмийн энергийн газарт албан ёсоор хандаагүй байгаа. Ерөнхийдөө эхлээд тайлан маягтаа хүргүүлнэ. Түүний дараа ажил хэргийн шугамаар холбогдоно.

Э.Сумъяа: Татварын хуулинд заасан цөмийн энергитэй холбоотой хураамжуудыг бүгдийг нь энэ маягтад оруулсан байгаа.

Б.Пүрэвээ: Надад нэг асуулт байна. Өнөөдөр 7 маягыг хэлэлцэхгүй гэсэн боловч заавал асуух зүйл гараад байна. Уг нь бол бид өмнө нь маягттай холбоотой бүх саналаа албан ёсоор хэлэлцээд, хүргүүлчихсэн байгаа. Гэхдээ одоо гарах гэж буй хуулиудыг хүлээхгүйгээр маягтаа баталчихсан тохиолдолд ахиж хэлэлцэх, батлах шаардлага гарах вий, энэ хэтийн төлөвийг харж чадсан уу? Яагаад би үүнийг хэлж байна гэхээр 2011 оны төсөвтэй хамтатгаад өсөн нэмэгдэх рояалтын шинэчилсэн хувилбар, цөмийн энергийн хуультай холбогдуулаад татварын ерөнхий хуульд орсон бүх хураамжуудыг нэгтгээд улсын

тэмдэгтийн хураамжийн тухай хууль руу оруулах хуулийн төсөл явагдаж байгаа юм байна лээ. Тэгэхээр эдгээрийг харгалзан үзэх хэрэг байна уу, үүн дээр ямар чиглэл баримталж байна вэ?

Э.Сумъяа: Үүнийг би хариулая. 4 сард ажлын хэсгийн хурлаас маягтуудаа Үндэсний зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлээ гэсэн чиглэлийг бид авсан. Харин Үндэсний зөвлөлийн 6 сарын 21-ны хурлаас маягтуудын талаар чиглэл авсан. Ямар чиглэл авсан бэ гэвэл бидний одоогийн энэ шинэчилсэн 7 маягтыг ирэх оны 1-3 дугаар сард хэрэглэнэ. Харин ирэх оны төсвийг 12 сарын 1-нээс өмнө хэлэлцэж дуусдаг. Иймд хэрэв татварын хуулинд түрүүний дурьдаж байсан болон ямарваа нэгэн өөрчлөлтүүд орсон тохиолдолд бид 12 сардаа багтаад маягтаа дахиж хянах боломжтой гэж үзсэн. Ийм учраас энэ маягт батлах ажил маань хүлээгдээд байгаа, өөр ямар ч зорилго байхгүй, гол нь маягтаа эртхэн хэлэлцүүлэхгүй яасан юм бэ гэсэн зэмлэлийг хүртэхгүйн тулд ажлын алба маань та бүхэнд наана нь танилцуулаад байгаа юм. Таны тавьсан асуудлыг анхааралдаа авлаа. Өөр асуулт байна уу?

Ш.Цолмон: Мягмардаш дарга байгаа дээр нэг зүйл тодруулж хэлэхэд манай засгийн байгууллагуудын тайланд харьяалах шатных нь төрийн аудитын байгууллага нь хяналт тавих гэж маягтад байгаа. Ийм нэг цоо шинэ зүйл орж ирсэн шүү, үүнийг та бүхэн сайн анхааралдаа аваарай. Энэ нь хэр бололцоотой юм бол? Үүн дээр гацах вий?

С.Мягмардаш: Жаахан ярвигтай л асуудал байна.

Э.Сумъяа: За өөр асуулт байна уу? Хэрэв байхгүй бол эхний асуудлаа дуусгая.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны тайлан гаргах ажлын явц, аудитын консерциумыг хугацаанд нь сонгон шалгаруулж, тайланг 2009 ондоо багтаан гаргахыг Ажлын албанд хариуцуулав.

2. Тайлан гаргах шинэчилсэн 7 маягт болон заавартай ажлын хэсгийн гишүүд танилцаж эцсийн саналаа Ажлын албанд албан ёсоор хүргүүлэхээр тогтов.

3. Татварын хуулинд өөрчлөлт орох эсэхийг хүлээж байгаад энэ оны 12 сардаа багтаж тайлан гаргах шинэчилсэн 7 маягтаа батлуулахаар тохиров.

Э.Сумъяа: За ингээд дараагийн асуудалдаа орье. Ноён Сэм Бартлет таныг өөрийн үнэлгээнийхээ талаар танилцуулахыг хүсье.

2.ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооноос гарсан шийдвэрийн биелэлтийг шалгасан байдлын талаархи танилцуулга

Сэм Бартлет: Баярлалаа. Өнөөдөр цаг зав гаргаж ирсэнд талархлаа

илэрхийлье. Би танилцуулгаа аль болох товчхон байлгахыг хичээе. Учир нь дөнгөж сая ноён Цолмон сүүлийн үед хийгдсэн сайн гэгдэх гол гол ажлуудын талаар та бүхэнд танилцууллаа. Тэгэхээр одоо миний танилцуулах зүйл бол Олон улсын удирдах хороонд Монголд хийсэн шалгалтынхаа үр дүнг танилцуулах тэр танилцуулгаа та бүхэнд танилцуулна. Хэрэв энэхүү танилцуулгад ямар нэгэн буруу ташаа, аль эсхүл орхигдсон зүйл байвал та бүхэн надад хэлээрэй. Энэхүү танилцуулга нь үндсэндээ 4 хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээрт, 4 дүгээр сард Удирдах хорооноос гарсан шийдвэр, хоёрдугаарт Удирдах хорооноос гарсан шийдвэрийн дагуу Монгол Улсын ОУИТБС-аас авсан хариу арга хэмжээ, гуравдугаарт хариу арга хэмжээг үнэлсэн миний үнэлгээ буюу дүгнэлт, дөрөвдүгээрт, цаашид ямар алхам хийвэл зохилтой талаар өөрийн санал зөвлөмж гэсэн үндсэн хэсгүүдээр би танилцуулгаа хийнэ. /Танилцуулгыг хавсаргав/

Э.Сумъяа: Үнэлгээнийхээ тухай товч, тодорхой танилцуулсан явдалд ноён Сэм Бартлет танд баярлалаа. Үнэлгээтэй холбогдуулан та бүхэнд асуух асуулт байна уу? Миний хувьд нэг санал байна. Үзүүлэн нь монгол хэл дээр, Сэм Бартлетийн тайлан нь англи хэл дээр байгаа. Англи тайланг нь хараагүй тул энд тодруулах зүйл гараад байна. Учир нь Монгол Улсын ОУИТБС-аас авсан хариу арга хэмжээ гэдэг хэсэг дээр хийсэн зүйлийг тэгэх ингэх гээд цаашид авах арга хэмжээ шиг биччихсэн байх юм. Энэ ямар учиртай вэ?

Б.Ганхуяг: Энэ орчуулгын бага зэрэг алдаа харагдаж байна. Учир нь гарчиг нь “авсан арга хэмжээ” гэж өнгөрсөн цаг дээр байгаа тул дотор нь дурьдагдах үйл ажиллагаануудыг өнгөрсөн цаг дээр бус үйл үгийн эс тухайлах хэлбэр дээр орчуулан бичсэн байгаа.

Э.Сумъяа: Сая Бартлет “Орлогын босгоо 50 сая төгрөг болтол бууруулжээ. Цаашид яах болоо” гэж хэллээ. Тэгэхээр Үндэсний зөвлөлд ажлын хэсэг санал оруулаад 10-50 сая төгрөгийн хоорондох орлоготой компанийудыг дотоодын аудитын компаниар аудит хийлгэнэ гэж шийдвэр гарсан байгаа. Үүнийг хийх дотоодын аудитын компаниуд байна уу гэвэл байгаа. Өөрөөр хэлбэл өнгөрсөн 2 тайланд дотоодын 2 компани гадаадын компаниудтай консорциум болж тайлан гаргасан. ОУИТБС-д нэгдсэн 31 орноос Монгол Улсын тайланг сайн гэж үнэлснээс үзэхэд манай дотоодын аудитын компаниудыг сайн гэж үнэлж байгаа гэж ойлгож байна. Мөн 2006 нэгдсэн тайланд хамрагдаагүй үлдсэн 22 компанийн тайланг гаргасан Төрийн бус байгууллага бий. Аудитын зардал нь ирэх оны төсөвт зардал нь тусгагдаж байгаа. Нөгөө талаас “2010 оны маягтыг боловсруулж байгаа” гэсэн байна. Гэтэл бид 2010 онд ашиглах шинэчилсэн 7 маягтыг ажлын хэсгийн хурлаараа 3 удаа хэлэлцээд, Үндэсний зөвлөлдөө танилцуулан батлуулах зөвшөөрлөө авчихсан байгаа. Гэхдээ Парламентад 2 төрлийн татварын тухай хуулийг шинэчлэх, өөрчлөх тухай яригдаж байгаа тул бид 12 сар хүртэл хүлээгээд байгаа гэдгийг тайландаа сайн тайлбарлан, ойлгуулж өгнө үү. Нөхцөл байдал ингэж шаардаад байна. Түүнчлэн 12, 13 дугаар шалгуурын тайлбар дээр “ЗГ-аас төрийн болон хувийн хэвшил Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг

даган мөрдөх тухай журам, заавруудад өөрчлөлт оруулсан” гэж бичсэн байна. Үүндээр “хууль” гэдэг үгийг оруулж өгөөчээ. 8 дугаар шалгуур үзүүлэлтийн тайлбар дээр “Засгийн газар болон Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийг сайн хамтран ажиллах” гэсэн байна. Гэтэл Үндэсний зөвлөл бол 3 удаа хуралдсан, өөрийнхөө хэмжээнд шийдвэрүүдээ гаргасан. Өөрийнхөө эрх мэдлээс дээш асуудал болох санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын хурлаар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулсан зэрэг дараа дараагийн удирдах дээд байгууллагуудаар батлуулах асуудлыг ч шийдвэрлэсэн байгаа. “ОУИТБС-ийн хуулинд ахиц гаргах” гэсэн байна. Тэгэхээр манай улс бол Парламентын засаглалтай учраас хууль боловсруулах процедур нь нарийн үе шатуудтай. Тэр үе шатуудынхаа дагуу явж байгаа. Тийм учраас хууль маань боловсрогдоод явж буй гэдгийг хэлж өгнө үү. Хуулийн төслийг олон нийтийн хэлэлцүүлэгт оруулах үед бид ОУНБД нарын газар руу хүргүүлж санал авах болно. Та бүхнийг бас манай хуулийн төсөлд саналаа өгөөрэй гэж хүсэх байна.

Ш.Цолмон: Англи хувилбар дээрээ “хуулинд ахиц дэвшил гарсан байна” гэж байна л даа.

Э.Сумъяа: Англи хувийг Цолмонд үлдээгээд явахыг хүсэж байна. За их баярлалаа. Та бүхэнд өөр санал байна уу?

Д.Бүүвэйжаргал: Төлсөн татварын хэмжээ 10-50 сая төгрөг байвал гэж та түрүүнд дурьдлаа. Ийм бага хэмжээнд босго тогтоогоод өгчихөөр хэтэрхий олон компаниуд болчихгүй юу?

Э.Сумъяа: Татварын хэмжээ багасах тусам хууль бус ажиллагаа гарах магадлал их байдаг гэж ярьдаг. Тийм учраас 10-50 сая төгрөг хүртэлх хэмжээг дотоодын аудитын байгууллагаар хянуулах гэж оруулсан байгаа. Өөр асуулт байна уу? За ноён Бартлетад баярлалаа. Таны хийсэн үнэлгээг манай ажлын хэсгийн гишүүд саяны миний хэлсэн саналыг оролцуулаад зөвшөөрч байна гэж байна. Дараагийн үе шатуудын талаар тодорхой мэдээлэл өгсөнд баярлалаа. Үе шат болгоныхоо эцэст манай Цолмонгоор дамжуулан бидэнд мэдээлэл өгч байхыг хичээнгүйлэн хүсч байна. Өнөөдрийн хурлын талаар бусад холбогдох хүмүүст бид мэдээлэх болно.

Ш.Цолмон: Миний хувьд танин мэдэхүйн чанартай нэг асуулт байна. Удирдах хороонд Баталгаажуулалтын хорооноос шийдвэрийн төсөл ордог уу, эсхүл ОУНБД нарын газраас шийдвэрийн төсөл ордог уу? Энэ талаар бидэнд товчхон мэдээлэл өгөхгүй юу?

Сэм Бартлет: Баталгаажуулалтын хороо бол нилээд чанга байгууллага. Өмнө нь Монгол улсыг 18 шалгуураар тэнцсэн гэж оруулахад 5 асуудлыг гаргаж ирж байсан. Одоогийн миний бэлдэж буй энэ тайланг ч гэсэн


нилээд хатуу шалгуураар шүүх байх. ОУНБД нарын газрын зүгээс тайлан гаргаж түүнийгээ Баталгаажуулалтын хороонд хүргүүлнэ. Хэрэв Баталгаажуулалтын хороо тухайн тайлангаас тодруулах зүйл байвал эргээд ОУНБД нарын газар руу хандана. Хэрэв тодруулах зүйл байхгүй бол Удирдах хороонд санал оруулна. Түүрүүнд дурьдаж байсан ОУНБД нарын газрын хувьд ийм үнэлгээ хийж байгаа хамгийн анхны тохиолдол юм. Ийм учраас ОУНБД нарын газрын хувьд ч, Баталгаажуулалтын хорооны хувьд ч, Удирдах хорооны хувьд ч энэ бол тодорхой хэмжээнд суралцах явц болж байна. Миний хувьд энэхүү үйл ажиллагааг амжилттай, үр дүнтэй болоосой гэж найдаж байгаа боловч Баталгаажуулалтын хорооноос гарах шийдвэрийг хүлээх үлдэж байна. Магадгүй та бүхэнд сонирхолтой байж болох юм. Киргизтан Улс бас саяхан баталгаажуулалтын тайлангаа дуусгасан. Энэ улсын хувьд 17 үзүүлэлтээр тэнцэж, 1 үзүүлэлтээр тэнцээгүй гэсэн дүгнэлтийг авсан. Улмаар Баталгаажуулалтын хорооноос “шаардлагыг бүрэн хангахад ойлтсон орон” гэсэн статусаар тодорхойлсон бөгөөд бас л яг танай дээр хийж буй үнэлгээг хийхийг зөвлөсөн. Миний ойлгож байгаагаар Киргизтаны ажлын хэсэг ирэх сард Монголд ирэх байх. Магадгүй та бүхэн тэдний ажлын хэсгийнхэнтэй Монголд ямар үйл ажиллагаа болсон талаараа өөрсдийн туршлагаас хуваалцах байх гэж найдаж байна.

Э.Сумъяа: Өөр асуулт байна уу? За баярлалаа. Таныг тайлан, үнэлгээгээ хамгаалах явцад Ажлын хэсгээс, Үндэсний зөвлөлөөс нэмэлт асууж, тодруулах зүйл байвал манай Цолмонгоор дамжуулан холбогдож болно. Бид асуултанд хариулах, нэмэлт тодруулга өгөхдөө бэлэн байх болно. Хуралд ирсэн та бүхэнд их баярлалаа. За ингээд өнөөдрийн хурлаа өндөрлөө.

Ажлын хэсгийн хурал 11 цаг 30 минутад дуусав.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Засгийн газрын ахлах референт,
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга

 Э.СУМЪЯА

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн

 Б.ДЭЛГЭРМАА